

“Ард даатгал” ХХК-д ердийн даатгалын зарим  
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3,  
Даатгалын тухай хуулийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн  
зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Ард даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрүүдээр ердийн даатгалын  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай. Үүнд:

- 1/ Хөрөнгийн (1.2.1);
- 2/ Бараа материалын (1.2.4);
- 3/ Мал амьтдын (1.2.13);
- 4/ Бүх төрлийн мэргэжлийн хариуцлагын (1.3.2);
- 5/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний хариуцлагын (1.3.9);
- 6/ Бэлэн мөнгө, үнэт цаасны (1.4.4);
- 7/ Гүйцэтгэлийн баталгааны (1.4.6).

2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж  
ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, “Ард даатгал” ХХК-ийн ердийн  
даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ  
тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрүүдийг нэмж бүртгэхийг Тамгын  
газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ